

**“ЮМ ҮЗЭГДЛИЙН НЭР + ӨНГӨ ЗААСАН НЭР” ЗАГВАРААР ӨНГӨ
ЗААСАН НЭР ҮҮСЭХ ТАНИХУЙН ҮНДЭС**
(монгол, англи хэлний өнгө заасан нэрийн жишээгээр)

О.Нандин-Эрдэнэ
/МУИС, Орхон сургууль/

Өнгийг олон талаас тайлбарлах оролдлого аль эртнээс улбаатай ажээ. Эртний тэр цагаас хойш шинжлэх ухааны хөгжил дэвшилтэй хамт өнгө судлах үйл явц хэл шинжээч, хүн судлаач, физикч, сэтгэл судлаач зэрэг өөр өөр салбарын судлаачдын анхаарлын төвд байсаар ирсэн ба одоо ч байсаар байна. Түүгээр ч барахгүй шинжлэх ухааны бие даасан салбар болтлоо өндөр түвшинд хөгжиж өнгө ба соёлын хамаарал, өнгө заасан нэрийн бэлгэдэл, өнгө физик, химийн үзэгдэл болох нь, өнгө таних бие зүйн үндэс, өнгө хүний сэтгэл зүйд нөлөөлөх нь, өнгө угсаа судлалын судлахуун болох нь, өнгө таних, нэрлэх танихуйн суурь, өнгө ард түмэн, хувь хүний сэтгэлгээний илрэл болох нь, өнгө заасан нэр үүсэх арга, хэлбэрийг багтаасан өнгө нэрлэх ёсон болох талаас нь судлах болжээ.

Монгол хэлэнд өнгө заасан нэрийг цөөнгүй эрдэмтэд судалсаар иржээ. Тухайлбал, О.Энхдэлгэр (Москва, 1996), Ш.Гэрлээ (УБ, 2000), Б. Уранчимэг (УБ, 2004) нарын нэг сэдэвт зохиолоос гадна өнгө бэлгэдэл зүй болох талаас оросын монголч эрдэмтэн Н.Л.Жуковская (1988), эрдэмтэн С.Дулам (1988, 1992, 1997, 2000, 2007), бусад талаас эрдэмтэн Я.Цэвэл (1956), Б.Ринчен (1977), Л.Балдан (1979), М.Базаррагчаа (1997), Д.Бадамдорж (2001) нар судалсан байна.

Сүүлийн үеийн танихуйн салбарын судалгаанаас үзвэл амьд ертөнцийн бусад төлөөлөгчид ч өнгө хэрхэн таньдаг талаар судалгааны ажил хэдийнээ эхлүүлсэн ажээ.

Ард түмнүүдийн хэлэнд байх өнгө заасан нэр тухайн ард түмний өнгө хүлээж авах, тогтоохтой хэрхэн холбогдохыг туршсан англи, орос, вьетнам монгол хэлний өнгө заасан нэрийн судалгааны баримтаас үзэхэд (Э.Ленненберг, Дж.Робертс, Буй дин Ми, О.Нандин-Эрдэнэ) тухай тухайн хэлэнд байгаа өнгө заасан нэрийн тогтолцоо өөр өөр болох нь тогтоогдсон байна. Эдгээр хэлээр хэлэлцдэг ард түмнүүд өнгө ялгах, таних тогтоохдоо хэлийг өөр байдлаар ашигладаг байна.

Эрдэмтэн Б.Берлин, Кэй (1966) нарын бүтээлд бүх өнгийг 1. Үндсэн өнгө (basic color term), 2. Завсрын өнгө (non-basic color term) хэмээн ангилсан байдаг.

Хамгийн түвэгтэй асуудал нь завсрын өнгө таних, нэрлэх явдал байдаг. Завсрын өнгө үүсэх хэд хэдэн арга байдгаас энэ удаад бид “юманд хандаж түүний өнгөөр өнгө заасан нэр үүсэх” тухайд авч үзсэн болно.

Өнгө заан нэрлэсэн үг ашиглах (дан үгээр нэрлэх, тухайлбал, улаан, хар, шар)

“цэвэр хэлний” арга болон “юманд хандаж түүний өнгөөр өнгө заан нэрлэх” арга (өрмөн шар, аляскан цагаан, алиман улаан, юнител ногоон) гэсэн хоёр үндсэн арга байна. Энэ хоёр аргыг хоёуланг ашиглах боловч аль нэг ард түмэн нэг аргыг түлхүү ашигладаг ажээ. Тухайлбал, Вьетнам хэлэнд юманд хандаж үүсмэл үүсгэх нь амархан (лиш цэцгийн өнгө, гадилын үрийн өнгө, жүржийн аалзны далавчны өнгө) ажээ. Мөн түүнчлэн юманд хандаж өнгө заасан нэр үүсгэхэд ард түмний танихуйн туршлага, амьдрах орчин, уламжлалт ахуй, соёл тусгалаа олсноор хэл хэлэнд нөгөө хэлэнд давтагдахгүй өвөрмөц нэрийн тогтолцоо бий болдог.

Өнгө заасан нэр нийлэмж үүсгэх хоёр хэлэнд хоёуланд нь түгээмэл хэрэглэдэг өөр нэгэн бүтээцтэй арга нь “**юм үзэгдлийн нэр+ өнгө заасан нэр**” загвар болно. Аль нэг юмны өнгө заан нэрлэхдээ бодит ертөнцөд бодитойгоор оршин буй тодорхой нэг юмны уугуул өнгийг тухайн зүйлийн хамт танин мэдэж, энэхүү танин мэдэх туршлагад суурилан өөр бусад юмны өнгө нэрлэхдээ уг юманд ханддаг нь ард түмний өөрийн амьдран суудаг орчноо танин мэдэх үйлтэй холбоотой. Аливаа ард түмэн бодит ертөнцийн юм, үзэгдлээс өөрийн ахуй, амьдралд илүү ойр, илүү таньж мэдсэн юм, үзэгдлийн шинж байдлыг өөр бусад юманд шилжүүлэн хэрэглэдэг. Ингэж хандвал өнгө заасан нэр үүсэх танихуйн суурь нь ард түмэн бүрээр ялгаатай, үндэсний онцлог шинжтэй байх учиртай.

Монгол, англи хэлний өнгө заасан нэр үүсэх танихуйн суурь чухам юу болохыг тодорхойлохын тулд тухайн хэл, соёлын төлөөлөгч өнгө заасан нэр үүсгэх, өнгө танихдаа чухам юунд хандаж байгааг тодруулах нь зүйтэй. Энэ зорилгоор ийм загвараар үүссэн өнгө заасан нэрийн зүйлчилсэн ангиллыг хоёр хэлний баримтаар зэрэгцүүлэн хийсэн болно. Нэг загвараар үүссэн хоёр хэлний өнгө заасан нэрийг зэрэгцүүлснээр тухайн ард түмний амьдралын өвөрмөц шинж, сэтгэлгээний онцлогтой танилцах боломжтой.

Монгол, англи хэлний тайлбар толь бичгүүдээс болон өнгө заасан нэр үүсгэх, өнгө таних, нэрлэх хоёр төрлийн туршилтаас илэрсэн нэгжүүдийг түүвэрлэн ангилал хийсэн болно.

Бидний тогтоосноор монгол хэлэнд энэ ангилалд багтах 106, англи хэлэнд 172 нэгж байна. Ангиллыг хүснэгтээр үзүүлье.

Монгол, англи хэлний “**юм үзэгдлийн нэр+ өнгө заасан нэр**” загвараар үүсэх нэгжийн зүйлчилсэн ангилал

№	Үүсэх арга	Монгол хэлэнд		Англи хэлэнд		Тайлбар
		Тоо	Хувь	Тоо	Хувь	
1	Байгалийн юмс, үзэгдлийн нэр + өнгө заасан нэр	30	28,3%	35	20,3%	2 хэлэнд идэвхтэй
2	Хүн, мал, амьтны нэр, эд эрхтний нэр + өнгө заасан нэр	15	14,1%	13	7,5%	2 хэлэнд идэвхтэй
3	Эрдэнэсийн чулууны нэр + өнгө заасан нэр	15	14,1%	19	11%	2 хэлэнд идэвхтэй
4	Бодисын нэр + өнгө заасан нэр	13	12,2%	24	13,9%	2 хэлэнд идэвхтэй
5	Жимс, ногооны нэр + өнгө заасан нэр	13	12,2%	28	16,2%	2 хэлэнд идэвхтэй

6	Эд юмны нэр + өнгө заасан нэр	12	11,3%	20	11,6%	2 хэлэнд идэвхтэй
7	Хоол унд, хүнсний зүйлийн нэр + өнгө заасан нэр	7	6,6%	12	6,9%	2 хэлэнд идэвхтэй
8	Ажил, мэргэжлийн нэр + өнгө заасан нэр	1	0,9%	7	4%	2 хэлэнд идэвхтэй
9	Улс, газар орны нэр + өнгө заасан нэр	0	0%	14	8,1%	Монгол хэлэнд идэвхгүй
	Нийт	106	100%	172	100%	

Эх сурвалж: Судлаачийн судалгааны үр дүнгээс

Хүснэгтээс харахад “юм үзэгдлийн нэр+ өнгө заасан нэр” загвараар монгол, англи хэлний өнгө заасан нэр үүсэх сэтгэлгээний 9 үндсэн арга байгаагаас 8 нь хоёр хэлэнд давхцах шинжтэй бол, харин англи хэлэнд буй “**улс, газар орны нэр + өнгө заасан нэр**” загвар монгол хэлнээс ялгаатай байна. Тодруулбал, монголчуудад сэтгэлгээний энэ загвар байна гэж хэлэх үндэслэл баримт, нотолгоогүй байна.

Дээрх ангилалд байгаа нэгжийн тоо хэл тус бүрт ялгаатай байх боловч ангилалд багтах өнгө заасан нэрсийг ажиглахад *цасан цагаан-snow white, зүлээн ногоон- grass green, тэнгэрийн өнгө sky blue, гал улаан-fire red* гэх мэт хүн төрөлхтний нийтлэг юмс үзэгдлийг нэрлэдэг байдлаараа ижил байна. Харин үүсэх загвар ижил боловч хандаж буй юм өөр, аль нэг хэлэнд идэвхтэй боловч нөгөө хэлэнд идэвхгүй өнгө заасан нэрийн тайлбар хоёр өөр хэлт ард түмний өнгө заасан нэр үүсгэх сэтгэлгээ, соёл, танин мэдэх үйлтэй холбоотой гэж үзэн тайлбарлах оролдлого хийлээ.

Одоо загвар тус бүрийг нарийвчлан авч дүн шинжилгээ хийе.

1. “Байгалийн юмс, үзэгдлийн нэр + өнгө заасан нэр” загвараар өнгө заасан нэр үүсэх нь:

Монгол хэлэнд энэ загвараар үүссэн 30 нэгж (28,3%), англи хэлэнд 36 нэгж (20,3%) байна. Зэрэгцүүлсэн хүснэгтээс үзэхэд монгол хэлэнд 30, англи хэлэнд 35 нэгж байгаа нь энэ загвар хоёр хэлэнд нийтлэг, бүтээцтэй гэж дүгнэлт хийх боломж олгож байна. Бусад аргатай харьцуулахад хамгийн олон жишээтэй тул монгол, англи хэлний өнгө заасан нэр үүсгэх сэтгэлгээний аргын хамгийн бүтээцтэй арга нь энэ арга гэж үзэж болох юм. Дээрх ангилалд хамаарах дүйцэлтэй болон дүйцэлгүй өнгө заасан нэрийг хоёр өөр хэл, соёлт ард түмэн чухам юунд хандаж юуны өнгийг өөр юманд шилжүүлэн хэрэглэж хэвшсэнийг тогтоож, дүйцэх болон дүйцэхгүй нэрийн адил төстэй хийгээд ялгаатай шинжийг олж харж танихуйн тайлбар хийх боломжтой. Баримтаар танихуйд суурилсан сэтгэлгээний онцлог ч илэрнэ.

Хоёр хэлний хамт олон юунд хандаж, юуны өнгийг уг юмны үндсэн өнгө гэж таньж, уг юманд хамаатуулан өнгө заасан нийлэмж үүсгэж байгааг ажиглан дараах байдлаар журамлах боломж байна. Үүнд:

А. Бүх хүн төрөлхтөнд танил байгалийн юмс үзэгдлийн нэрээс хоёр хэлэнд нийтлэг, адил төстэй өнгө заасан нэр үүснэ.

Б. Монгол, англи хоёр үндэстэнд хоёуланд танил байж болохоор байгалийн юм, үзэгдлийн нэрээс өнгө заасан ялгаатай нэр үүснэ. Ялгаа нь аль ард түмэн уг юмыг хэрхэн яаж таньсан, аль шинж тэдний хувьд чухал зэрэгтэй холбоотой.

В. Зөвхөн монголчуудад танил, амьдрал ахуйд нь ойр байдаг юмны нэрээс

өнгө заасан нэр үүснэ. Эдгээр нь үндэсний сэтгэлгээ, ахуй, соёл, танихуйн тайлбар шаардана.

Г. Зөвхөн англи хэлтэн ард түмэнд танил, амьдрал ахуйд нь ойр байдаг юмны нэрээс өнгө заасан нэр үүснэ. Эдгээр нь үндэсний сэтгэлгээ, ахуй, соёл, танихуйн тайлбар шаардана.

Энэ ангилалд нийт 43 жишээ байгаагийн 23 нь давхцсан бол англи хэлэнд дүйцэлгүй *zoson ulaan, цээл ногоон, сухай улаан, нил цэцгийн өнгөт, яргуй цагаан, үүлэн цэнхэр, шороон бор*, монгол хэлэнд дүйцэлгүй *thunder gray, daffodil yellow, cornflower blue, camellia red, canary yellow, tobacco colored, mallow pink, midnight black, pistachio green, poppy red, sage green (kind of herb)* зэрэг баримт байна. Нөгөө хэлэнд дүйцэлгүй нэр болон чухам юунд хандаж өнгө заасан нэр үүсгэж байгаа нь эргэцүүлэх, соёл, танихуйн туршлага, сэтгэх онцлогтой холбон тайлбар хийх үндэс болох юм.

"Gal-fire", "тэнгэр-sky", "цас-snow", "ус-ocean, sea", "хөрс- soil", "үүл – cloud" зэрэг хүн төрөлхтний нэг дэлхий ертөнцөд амьдарч байгаль, дэлхийн нэг юм, үзэгдлийг нэг өнгөөр мэдэрдэг нийтлэг талтай холбоотойгоор үүссэн хоёр хэлний яг ижил нэгжүүд байгааг хүн төрөлхтний танихуйн нийтлэг туршлагатай холбон тайлбарлах боломжтой. Хоёр хэлэнд *"зандан улаан - mohagony red", "гацуур ногоон – spruce green", "элсэн шаргал –sandy yellow", "шороон саарал - soil colored"* зэрэг ижил нэгжүүд байна.

Харин халуун орны ширэнгэн бүсэд амьдардаг, цас хараагүй, таниагүй хүмүүс *"цасан цагаан"* гэх өнгө заасан нэр үүсгэхгүй нь мэдээжийн хэрэг билээ. Монголчууд *"далайн ногоон", "тэнгисийн хөх"* гэж өнгө заасан нэр үүсгэхгүй, эдгээр нэр монгол хэрэглэнд тааралдаж байвал орчуулгын шинжтэй гэж үзэхээс өөр аргагүй. *"Зосон улаан", "цээл ногоон", "сухай улаан", "яргуй цагаан", "шороон бор", "үүлэн цэнхэр", "нил цэцгийн өнгөт"* нэгжүүд англи хэлэнд дүйцэлгүй байна.

Англи хэлний *"thunder gray", "daffodil yellow", "cornflower blue", "camellia red", "canary yellow", "tobacco colored", "mallow pink", "midnight black", "pistachio green", "poppy red", "sage green"* зэрэг нэгжүүд монгол хэлэнд огт дүйцэлгүй байна.

Нэг хэлэнд хэвшсэн, нөгөө хэлэнд дүйцэлгүй өнгө заасан нэрүүдийн тухайд эдгээр өнгө заасан нийлэмж үүсэх болсон уг юм нь нэр байгаа ард түмэнд эртнээс танил, ахуйд өргөн хэрэглээтэй юмны нэр байх ажээ. Эдгээр өнгө заасан нэр үүсэх чухал нөхцөл нь тэдний амьдралд ойр байдаг зүйл, тухайлбал, тухайн газар оронд нь ургадаг өвс ургамал, далайтай ойр амьдардаг газар нутгийн хүчин зүйл болох юм.

2. “Хүн, мал, амьтны нэр, эд эрхтний нэр + өнгө заасан нэр” загвараар өнгө заасан нэр үүсэх нь:

Энэ ангилалд монгол хэлний *хонин цагаан, хонин бор, тугал хар, ботгон бор, чандган цагаан, үнэгэн шар, мэлхий ногоон, хун цагаан, дун цагаан, элгэн хүрэн, элгэн улаан, цусан улаан, ясан цагаан, биений өнгөт* англи хэлний *foxy, swan white, raven black, liver colored, blood red, bone white/ ivory, flesh colored, mouse gray, oxblood, parrot blue, dove colored, baby blue* зэрэг нэгж байна.

Эдгээрээс үнэгэн шар- foxu, хун цагаан- swan white, хэрээн хар- raven black, элгэн хүрэн - liver colored, цусан улаан- blood red, ясан цагаан- bone white нэгжүүд хэлбэр, утгаар бүрэн дүйж байгаа нь хоёр хэлээр хэлэлцэгч ард түмнүүдийн нийтлэг танихуйн туршлагаар тайлбар хийх зүйл юм.

Монгол хэлний хонин цагаан, хонин бор, тугал хар, ботгон бор зэрэг нийлэмж үндэсний онцлог шинжтэй, англи хэлэнд давтагдахгүй байна. Түүнчлэн англи хэлний mouse gray, oxblood, parrot blue, baby blue гэх мэт нийлэмж монгол хэлэнд байхгүй байгаа нь бас үндэсний онцлог шинжтэй гэх тайлбарт багтана.

Монгол хэлэнд өнгө заасан нэр үгэнд оролцсон “хонь”, “ботго”, “тугал” гэх зэрэг үг нь монголчуудын таван хошуу малд холбогдох бол англи хэлэнд өнгө заасан нэр үүсэхдээ тэдний гэрийн тэжээмэл амьтны нэр оролцож бүтсэн байгаа нь тухайн хоёр хэлээр харилцагч ард түмний аж амьдрал, ахуйтай холбоотой хэмээн үзэж байна.

3. “Эрдэнэсийн чулууны нэр + өнгө заасан нэр” загвараар өнгө заасан нэр үүсэх нь:

Ангилалын энэ төрөлд монгол хэлний 15 (маргад ногоон, хааш цагаан, оюу ногоон, бадмаараг улаан, хуван шар, сувдан цагаан, танан цагаан, шүрэн улаан, гантиган цагаан, номин хөх, хааш ногоон, номин ногоон) нийлэмж багтсан бол, англи хэлний 18 (emerald green, jade white, turquize green, ruby colored, pearl white, coral red, jade green, emerald green, sapphire green) нийлэмж багтжээ.

Хоёр хэлний энэ ангилал үүсэх болсон гол үндэс нь нийлэмжийн бүрдүүлбэрт буй эрдэнэсийн чулууны нэр бөгөөд хоёр хэлээр хэлэлцэгч ард түмнүүдэд танил, нийтлэг тул ялгаа төдийлөн ажиглагдсангүй хэмээн үзэж байна. Үнэт чулуу таних боломж нөхцөл адил, ахуй амьдралдаа өргөн хэрэглэдэг нь өөр хоорондоо төдийлөн ялгаагүй адил төстэй нэр үүсэхэд хүргэжээ.

4. “Бодисын нэр + өнгө заасан нэр” загвараар өнгө заасан нэр үүсэх нь:

Энэ ангилал харьцангуй олон нэртэй (нийт 37 нэр, үүнээс монгол 13, англи 24) томоохон бүлэг болж байна.

Эндээс үүдэн бодисын нэрэнд хандаж өнгө заасан нэр үүсгэх нь хоёр хэлэнд бүтээцтэй загвар гэж дүгнэх боломжтой. Эдгээрээс 8 нэр (мөнгөн цагаан- silvery white, шохойн цагаан- chalky, alabaster white, алтан шар- golden yellow, зэсэн улаан- copper red, зуулин шар - brass colored, боронзон улаан- bronze, үнсэн саарал- ash gray, нүүрсэн хар - coal black) нийлэмж хоёр хэлэнд хэлбэр ба утгаар бүрэн давхцаж байна гэж үзэх бол монгол хэлний үнсэн хөх, аранжсин улаан, тугалга хар, төмрөн саарал, тугалган цагаан нийлэмж англи хэлэнд дүйцэлгүй байна. Үүний нэг адил англи хэлэнд metallic gray, calcium white, cobalt blue, sulphur yellow, chrome orange, lead black, tin black, ore green, opal white, iron gray, alum white, burnt sienna, cadmium orange, cadmium yellow, platinum black, powder blue нийлэмжүүд монгол хэлэнд дүйцэлгүй байна.

Монгол, англи хэлэнд энэ загвараар өнгө заасан нэр үүсэхдээ гол төлөв хэлбэр ижил байгаа нь дээрх нийлэмжүүдийн бүрдүүлбэрт орж буй химийн элементүүд монгол, англи хэлтнүүдийн хувьд нийтлэг, танил учир өнгө мэдрэх, нэрлэх, өнгө

үүсгэх сэтгэлгээ хоёр ард түмэнд ойролцоо болсон хэмээн үзэж байна.

5. “Жимс, ногооны нэр + өнгө заасан нэр” загвараар өнгө заасан нэр
үүсэх нь:

Монгол, англи хэлэнд энэ загвараар өнгө заасан нийлэмж үүсэх арга нь ижил боловч, ямар жимс нутагт нь ургадаг, ямар жимсэнд хандаж өнгийг нь нэрлэдэг, уг жимсийг ямар өнгөтэй гэж үздэг уламжлал өөр байгаагаас шалтгаалан ялгаа гарахаас гадна нэг хэлэнд аль нэг жимс өнгө заасан нэр үүсэх загвар болдог бол, нөгөө хэлэнд энэ жимсний нэрээс өнгө заасан нэр үүсэхгүй байдлаар ялгаатай байна. Монгол хэлэнд бид 13 нэр бүртгэсэн бол англи хэлэнд энэ төрлийн 28 жишээ байна.

Дээрх хүснэгтийн эхэнд монгол хэлний *жимсэн улаан*, англи хэлний *Berry blue* (жимсэн хөх) нэр тус тус байгаа нь аль нэг тодорхой жимсэнд хамааруулаагүй, ерөнхий нэр байх ч монгол хэл, соёлын төлөөлөгч “*жимсэн улаан*” гэж, англи хэл, соёлын төлөөлөгч “*жимсэн хөх*” гэж сэтгэдэг байдлыг харуулжээ. Монголчууд алим “*улаан өнгөтэй*” гэж үздэг бол англи хэлтэн ард түмэн алим “*ногоон*” гэж сэтгэдэг ажээ.

Монгол хэлэнд жимсний нэртэй холбогдох өнгө заасан бусад *мойл хар, үзмэн ягаан, алиман улаан, үзмэн хүрэн, нимбэгэн шар, цөцгийн өнгөт, жүржсийн өнгөт* гэсэн нэр байгаа нь бүгд тодорхой жимсний үндсэн өнгөтэй уг юмны өнгийг адилтган нэрлэдэг монгол сэтгэлгээг харуулж байна. Баримтаас үзэхэд монгол хэлэнд ногооны өнгөтэй юмны өнгийг адилтган харж өнгө заасан нэр үүсгэсэн баримт бидний түүвэрлэсэн нэгжийн хүрээнд үгүй байна.

Харин англи хэлэнд жимс, ногоо, самарны нэртэй холбогдон нийлэмж үүсгэх нь монгол хэлтэй харьцуулахад элбэг болох нь амьдрал ахуйдаа өргөн хэрэглэдэг жимс, хүнсний ногооны нэртэй холбон нийлэмж үүсгэсэн нь жишээ баримтаар харагдаж байна.

Энэ дэлхий дээр жимс, ногоог хүнсэндээ хэрэглэдэггүй ард түмэн бараг үгүй бизээ. Иймээс өнгө заасан нэр үүсгэхдээ жимсний нэрээс, хүнсний ногооны нэрээс өнгө заасан нэр үүсгэдэг олон жишээ бий. Гэхдээ монголчууд нүүдлийн иргэншилтэй ард түмэн учир таван хошуу малаасаа гарах идээ, ундааны нэрээс өнгө заасан нэр үүсгэх нь элбэг. Орчин цагт бид янз бүрийн жимс, ногоог хоол хүнсэндээ хэрэглэх болсонтой холбоотойгоор жимс, ногооны нэрээс өнгө заасан нэр үүсгэж байгаа хэв шинжтэй байна. Англи хэлт, суурьшмал иргэншилтэй ард түмний хувьд жимс, ногоог өдөр тутмын амьдралдаа өргөн хэрэглэж ирснээс жимс, ногооны нэрээр нэрлэх нь гарцаагүй юм. **Жимс** гэх үгийг монгол хэлэнд *ургамлын идэж болох амтлаг үрийг нь*; (Я.Цэвэл, 1966), англи хэлэнд **Fruit-the ripened reproductive body of a seed a plant**; (Collin’s Dictionary, 2000) ургамлын үрийн боловсорч байгааг нь хэмээн тайлбарласан байна.

Аль ч ард түмний хэлэнд үгийн сангийн аль нэг зүйлийг нэрлэсэн нэгж байна гэвэл соёлын хүчин зүйл байна гэж үзэх боломжтой бөгөөд уг нэрлэх зүйл нь байгаа учир зайлшгүй шаардлагаар гарч ирсэн болно. Харин уг зүйл байхгүй бол түүнийг нэрлэн тухайлсан үгийн сангийн нэгж байх шаардлагагүй ба соёлын хүчин зүйл

байхгүй¹ гэсэн Р. Ладогийн (Ладо, 2009) үзэл баримтлалтай санал нийлж байна.

Монголчууд мойл жимсний харагдах байдлыг таньж мэдсэн тул уг жимсний нэрээс *мойл хар* гэх өнгө заасан нэр үүсгэж байна. Гэхдээ энэ нэр нь эмэгтэй хүний нүдийг дүрслэхэд хэрэглэгддэг. Монгол хүн хар, бор нүдийг (*алаг нүдтэй, мойл хар нүдтэй*) илүү таашаадаг бол, англичууд ногоон, цэнхэр нүд (*piercing blue eyes, vivid blue eyes, bright green eyes*) таашаадаг нь энэ хоёр ард түмний өөр хоорондоо илт ялгаатай сэтгэлгээг илэрхийлж хандаж буй юм нь өөр байх үндэслэл болно. Монголчууд *мууран ногоон нүдтэй, цэхэр ногоон нүдтэй* гэхчилэн үл таашаасан хандлагатай.

Англи хэлний “*berry blue*” гэсэн нэгж хэлбэрийн хувьд ойролцоо мэт боловч ***berry blue***- *any of various small edible fruits such as the black berry, gooseberry*; хэмээн тайлбарласнаас харвал хар өнгөтэй жимс (*gooseberry* – мойл жимс) болно гэж үзээд дүйцүүлсэн болно. Энэ үгийг англичууд “*berry blue eyed*” хөх жимсний өнгөт нүдтэй гэж яавч ярихгүй. Тиймээс энэ мэт хэлбэрийн хувьд ойролцоо боловч утгын хувьд ялгаатай нэгж байна.

Монгол хэлний *мойл хар, үзмэн ягаан, алиман улаан, үзмэн хүрэн, жимсэн улаан* зэрэг нь монгол хэлний өнгө заасан нэрийн санд тогтвортой хэрэглээтэй нэгжүүд байна. Англи хэлэнд *berry blue* (*бөөрөлзгөний өнгөт, хөх жимс*), *grape coloured* (*усан үзмийн өнгөт*), *nut brown* (*самрын өнгөт*), *lemon yellow* (*нимбэгэн шар*), *tomato red* (*улаан лоолийн өнгө*), *plum blue* (*чавганы өнгөт*), *apricot yellow* (*чангаанзан шар*), *cherry red* (*интоор улаан*), *pea green* (*вандуйны өнгөт*), *mustard yellow* (*гичний өнгөт*), *ginger brown* (*цагаан гаа*), *apple green* (*алиман ногоон*), *olive green* (*чидун жимс*) зэрэг өнгө заасан нэрүүд байна. Гэтэл бид цаад холбогдож байгаа усан үзэм, *самар, нимбэг, чангаанз, интоор, гич* зэргийг чухам юу вэ гэдгийг мэддэг, мөн өнгийг нь мэдэх боловч өнгө заасан нэр болон нийлэмж үүсгэхдээ чухам юуг тодорхойлдог нь сонин. Тухайлбал: дурын зүйлийг (алим, цамц, ном, бөмбөг) “алиман улаан” өнгөтэй гэхгүй нь ойлгомжтой. Монголчууд “алиман улаан хацартай” (англи хэлэнд үүнтэй төстэй *red cheeked*) гэж ярьдаг. Гэтэл англи хэлэнд “*apple red*” гэсэн өнгө заасан нэр англи хэлний аль ч толь бичигт үгүй байна. Харин ***apple green*** толь бичигт ([www. wordreference.com/onlineenglishdictionaries](http://www.wordreference.com/onlineenglishdictionaries)) 1. *a bright, light green or moderate yellowish-green; (гэгээлэг ногоон өнгө эсвэл зөөлөн, шаравтар ногоон өнгө)* 2. *An apple green carpet; (алиман ногоон өнгөтэй хивс)* гэжээ. Гэтэл монголчуудын хувьд алиман ногоон хивс гэх хэрэглээ ер бусын, энэ мэтээр ярихгүй нь илэрхий. Тэгэхээр алим жимсний өнгө (бодит утга нь алим) английн ард түмэнд тогтсон өнгө заасан нэр болж байна гэдэг нь өнгө заасан нэр аль ч ард түмний соёл танихуй, сэтгэлгээний хэв шинжийг харуулж чадах юм гэдгийг баталж байна.

Энд бид нэгэн зүйлийг тэмдэглэхэд, өнгө заасан нэгж дээрх байдлаар үүсэхдээ тухайн нийлэмжийг бүрдүүлж буй зүйл нь шинж чанар, төрөл янзаасаа хамаарч хоёр хэлэнд хувилбартай байх шинжтэй болох нь ажиглагдаж байна.

¹ Ладо Р (2009) *Лингвистика поверх границ культур*, Новое зарубежной лингвистике, Вып. 25, М, 56

6. “Эд юмны нэр + өнгө заасан нэр” загвараар өнгө заасан нэр үүсэх нь:

Энэ бүлэгт монгол хэлний 12, англи хэлний 18 нэр багтаалаа. Үүнд, (*шаазан цагаан- china white, хөөсөн цагаан- foam white, тоосгон улаан - brick red, бэхэн хар - ink black, хөөн хар- soot black, ноосон цагаан- fleecy white*) хоёр хэлэнд дүйх боломжтой ба монгол хэлний 6 нэр (*хөвөн цагаан, өдөн цагаан, хадган цэнхэр, лавай цагаан, бэхэн ягаан, шунхан улаан*) англи хэлэнд дүйцэлгүй, үндэсний ахуй, сэтгэлгээний онцлог бүхий нэрүүд бол англи хэлний *tobacco colored, opera pink, electric blue, golf green, engine red, gun metal gray, signal red, Jet black, Windsor green, Bottle green, Golf green, Smalt blue, Snuff colored* гэх нэрүүд монгол хэлний баримттай дүйхгүй байна.

Эд юмны нэрээр өнгө заасан нэр үүсэж буй эдгээр ангилалд дүйцэлтэй нэр цөөн байна. Монгол хэлэнд “*хадаг*” гэх үг “*цэнхэр*” гэх өнгө заасан нэртэй холбогдож байна. Монголчууд таван өнгийн хадгийг эрхэмлэдэг ба эдгээрээс хадган ногоон, хадган цагаан гэх мэт нэр үүсэхгүй харин хадган цэнхэр гэж үүсэж байгаа нь монголчуудын хувьд эрхмийн бөгөөд бэлгэдлийн шинж агуулсан байдлаар өнгө заасан нэр үүсэж байна.

“Шунх” гэх үг Я.Цэвэл авхайн тольд “чулуулгаас гарах нэгэн зүйл улаан өнгөтэй будаг” (Я. Цэвэл, МХТТТ, 1966) гэжээ. Чулуулгаас угтаа ямар ч өнгийн будаг гарч болно. Гэтэл “шунхан улаан” гэж өнгө заасан нэр үүсэж байгаа хэрэглээ нь тогтсон хэрэглээ болж байна. Монголчууд “цус”- ыг эерүүлж мөн “шунх” гэж хэлдгээс цусан улаан гэлгүй “шунхан улаан” гэж хэлдэг ёс бий билээ. Эрдэмтэн С.Дулам “улаан өнгийн бэлгэдэл нь үүсэл гарлынхаа хувьд байгаль ертөнц, хүний соёл иргэншил дээрх хамгийн чухал үзэгдэл болсон гал, галын дөлийг төлөөлдөг. Энэ нь хүний бие дээр авч хэлэхлээр эрүүл биеийн цусны өнгө шунх улаантай (ул) авцалдан үлгэр туульсын баатдын идэр чийрэг, цог золбоот дүр төрхийг бүтээдэг”² гэжээ. Бид шунх гэх үгийг байгалийн будаг гэж ухаарч энэ ангилалд оруулсан болохоо хэлье.

Англи хэлний “fleece” (the coat of wool that covers a sheep or similar animal) монгол хэлний “ноосон” (адгуус амьтны биеийг бүрхсэн үс; хонины ноос, тэмээний ноос) гэснээс ижил байна. “Цагаан” өнгө заасан нэртэй холбогдож байгаагаар хонины ноосыг хэлсэн нь ойлгомжтой. Гэтэл монгол хүнд “ноосон цагаан” гэхэд түүхий ноос буухаас биш, үйлдвэрийн аргаар боловсруулсан ноос буухгүй. Англичуудын хувьд “fleece white нь “a white fabric with a soft, silky pile, used for warmth, as for lining garments” (<http://dictionary.reference.com/>) гэж цагаан өнгөтэй хөвөн даавуун материал болох юм. Эндээс үзвэл аливаа ард түмэнд өөрсдийнх нь амьдралд байх зүйлээрээ ижилсэх хэлний нэгжүүд байх боловч цаад ухагдахуун, юмны төсөөлөл ондоо байна.

² Дулам С. (2007) “Монгол бэлгэдэлзүй II Өнгийн бэлгэдэл зүй, Зүг чигийн бэлгэдэл зүй”, УБ, 41-р тал

7. “Хоол унд, хүнсний зүйлийн нэр + өнгө заасан нэр” загвараар өнгө заасан нэр үүсэх нь:

Энэ ангилалд хамаарах нэрийн тоо хоёр хэлэнд бусад загвартай харьцуулахад цөөн боловч үндэсний ахуй, соёл, сэтгэлгээний онцлог илэрхийлэх талаас нэн сонирхолтой. Монгол хэлэнд *өрмөн шаргал, тосон бор, өөхөн цагаан, сүүн цагаан, ангир шар, өндгөн цагаан* зэрэг нийлэмж байхад англи хэлэнд *milky white, tea rose, chocolate brown, cacao brown, honey yellow, wine red, caramel red* гэх зэрэг нийлэмж үүсэж, бидний жишээнээс харахад монгол, англи хэлэнд зөвхөн *сүүн цагаан- milky white, шokolадан бор- chocolate brown* гэсэн нийлэмж таарч байгаа бол бусад жишээний хувьд ялгаатай байна. Монголчуудын хүнсэндээ хэрэглэж ирсэн цагаан идээний нэр өнгөний хамт хэлэндээ шингэсэн, өөр бусад ард түмний хэлэнд давтагдахгүй өвөрмөц шинжтэй бол англи хэлэнд *cacao, chocolate, caramel, wine, biscuit* зэрэг нэрээс үүссэн өнгө заасан нэр байгаа нь тэдний эрт цагаас байнгын хэрэглээ болгож хэвшсэн хүнсний зүйлийн өнгө байх ажээ.

8. “Ажил мэргэжлийн нэр + өнгө заасан нэр” загвараар үүссэн өнгө заасан нэр:

Энэ загвараар үүссэн өнгө заасан нэр хоёр хэлний баримт илт зөрөөтэй байх, улмаар сэтгэлгээ ялгаатай байгаагийн илрэл болсон сонирхолтой загвар байна. Бусад загвартай харьцуулах жишээ баримт цөөн тул бүтээцтэй загвар гэж үзэх аргагүй ч хоёр хэлэнд энэ загвар ер нь байгаа нь сайн танил болсон юманд хандаж өнгө нь тогтвортой бол өнгө заасан нэр үүсэж өөр бусад юмны өнгө заах боломжтойг харуулсан баримт болох юм. Англи хэлэнд зарим нэр ажил мэргэжлийн нэрээс үүссэн өнгө заасан долоон нэгж, монгол хэлэнд нэг байна.

Англи хэлний *“hunters gray”, “photograher’s gray”, “navy blue”, “royal blue”, “royal purple”, “regimental green”* өнгө заасан нэрүүд толь бичигт бүртгэгдсэн бол толь бичгийн баримтаар монгол хэлэнд илрээгүй боловч, сэтгэц хэл шинжлэлийн туршилтаар *цэрэг ногоон* гэх нэг жишээ бүртгэгдсэн. Энэ нь англи хэлний *regimental green (military uniform) нэгжтэй дүйх юм*. Бусад загвартай харьцуулахад энэ загвар хоёр хэлэнд хоёуланд нь бүтээц багатай. Монгол хэлний өнгө заасан энэ нэр үүсэхэд *цэрэг ногоон* (цэргийн албан хаагчдын хувцас) гэж тухайн ажил мэргэжил эрхэлдэг хүмүүсийн хувцасны өнгө нөлөөлж, хэлэнд хэвшжээ. Бид англи хэлний дээрх долоон нэгжийг ажиглахад тайлбар мөн адил байх юм.

9. “Улс, газар орны нэр + өнгө заасан нэр” загвараар өнгө заасан нэр үүсэх нь:

Англи хэлэнд улс орны нэртэй нийлэмж үүсгэн өнгө заасан нэр үүсэх загвар байгаа бол (14 нэгж), монгол хэлэнд ийм загвараар үүссэн өнгө заасан нэр бидний түүвэрлэсэн баримтын санд үгүй байна. Англи хэлний энэ загвараар үүссэн өнгө заасан нэр тухайн газар орны ямар нэгэн онцгой хэв шинж, онцлогтой холбоотойгоор үүсдэг ажээ.

Жишээлбэл, *Havana colored* гэх өнгө заасан нэр Хавайн арлын байгалийн мөнхийн ногоон өнгөөс, *African black* гэх өнгө заасан нэр африкийн иргэдийн арьсны өнгө хар байдгаас шалтгаалан үүссэн гэж үзэхэд үгүйсгэх аргагүй юм.

Үүнчлэн *french red*- франц улаан дарсны өнгө, *oxford blue*- их сургуулийн дүрэмт хувцасны өнгө, *alaska white*- энэ нутгийн цасны өнгө тус тус өнгө заасан нийлэмж үүсэж хэвшихэд хүргэжээ. Мөн түүнчлэн англи хэлэнд энэ загвараар үүссэн “*indian orange*”, “*cambridge blue*”, “*turkey red*”, “*royal blue*” нийлэмжүүдийг олж тэмдэглэлээ.

Дүгнэн хэлбэл:

1. Монгол, англи хэлний тайлбар толь бичигт байх өнгө заасан нэрийн тоо ойролцоо боловч, өнгө заасан нэрийн судалгааг англи хэлний баримтаар сайн хийсэн, тусгай олон толь бичиг гаргаж өнгө заасан нэрийн баримтыг бүртгэн журамласан зэргээс үүдэн англи хэлний өнгө заасан нэрийн баримт монгол хэлтэй харьцуулахад хавьгүй их байна. Энэ нь монгол хэл шинжлэлд өнгө судлалын ухаан төдийлөн хөгжөөгүй, энэ талаар хийсэн эрдэмтэн, судлаачдын ажил цөөн, тусгай толь бичиг байхгүйтэй холбоотой гэж хэлж болохоор байна.

2. Хоёр өөр хэл, соёлт ард түмний чухам юунд илүү хандаж өнгө заасан нэр үүсгэж байгаа ерөнхий аргууд ойролцоо боловч, арга тус бүрт хамаарах өнгө заасан нэр бүхий нэгж цаад хандаж буй зүйл нь өөр (монгол хэлэнд “өрмөн шаргал”, “хонин бор”, “ботгон бор”, “хонин цагаан” гэхчилэн, англи хэлэнд “*honey yellow*”, “*Alaska white*”) байгаа нь үндэсний онцлог шинжтэй нэгж үүсэх суурь болж байна.

3. Англи, Америк улсад өнгө судлалын шинжлэх ухаан эрчимтэй хөгжсөнийг харуулах англи хэлний өнгө заасан нэрийн физикийн, анагаах ухааны, санхүүгийн, улс төрийн³ аж үйлдвэрийн гэхчилэн тусгай толь бичиг олон байгаагаас гадна өнгө заасан нэр томъёоны, өнгө заасан нэрийн тезаурус⁴, ойролцоо ба эсрэг утгын⁵, өнгө заасан нэрийг өнгө будгийн тайлбараар харуулсан толь, өнгө заасан нэрийн тайлбар толь бичгүүд байна. Түүнчлэн өнгө заасан нэрийн хэрэглээг заасан, тухайлбал, зөвхөн хүний арьсны өнгө заасан (*words to describe skin color*), өнгө заасан энгийн нэр (*general words to describe colour*)⁶ зэрэг толь бичиг байгаа нь цаашид бид ч энэ мэтээр нарийвлан судлах, олон төрлийн толь бичиг зохиож нийтийн хүртээл болгох боломжтой, шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

4. Өнгийг утга, соёл, хэлний тэмдгийн үүднээс судлахдаа өнгөний утгыг тайлбарын аргаар илэрхийлэхийг голчилж үздэг. Зарим судлаач “Тайлбар нь хэлбэр, утгын хоорондын тайлбарлах холбоог илэрхийлэх ёстой... Тайлбар нь зөвхөн ойролцоо утгатай илэрхийлэл болоод зогсохгүй хувь хүний хандлага буюу бодгалийн үнэлэмж давамгайлах нь цөөнгүй ажээ. Энэ нь тайлбарлаж байгаа үгийн утгад тухайн бодгаль, хувь хүний ертөнц тусгалаа олдог гэсэн үг юм... Утга бол илэрхийлэл агуулдаг мэдээлэл юм. Ийм учраас хэл шинжээч тухайн тэмдэг болон бусад тэмдэг хоорондох холбоог хэдий чинээ сайн олж тогтоовол, хэлний илэрхийлэл нь төдий чинээ оновчтой болно... Хэлний тэмдгийн утга нь өөр тэмдэгтэд шилжүүлсний үр дүнд, өөрөөр хэлбэл, тайлбараар тухайн тэмдгийн

³ <http://www.thefreedictionary.com/>

⁴ <http://graphwords.com/>

⁵ <http://www.oxfordlearnersdictionaries.com/>

⁶ <http://www.macmillandictionary.com/us/thesaurus>

утга илүү бүрэн дүүрэн гарна⁷ гэж үзсэн нь бидний энд судлан тайлбарлаж буй асуудалд учир холбогдолтой гэж үзэж байна.

5. Өнгө заасан нэрийн тухай үндсэн тайлбар нь тухайн өнгийг агуулагч хэвшсэн биет болох юм. Жишээ нь, зүлэг, навч, цас, нүүрс, цус зэргийн “тогтвортой” өнгийг заасан тэмдэглэгээ нь дэлхийн янз бүрийн хэлэнд байдаг ижил үзэгдэл гэж болно. Харин хагдарч байгаа ургамал ямар өнгөтэй вэ гэдэг асуултанд хариулахад хэл хэлэнд нэлээн бэрхтэй юм. Түүнчлэн хүрэн ягаан, саарал ягаан өнгийг тайлбарлахад улам бүр бэрхшээлтэй болно. Учир нь дээр жишээлсэн шиг тийм ийм юмны өнгөтэй адил гэж тайлбарлах арга байдаг.

6. Тайлбарын өөр нэг арга нь тухайн өнгө заасан нэрийг бор бараан, гүн шар мэтээр бусад өнгө заасан юм үзэгдлийн шинж чанарыг заасан нэрээр дам тайлбарлах арга юм. Гэвч энэ нь таамагласан, тодорхойгүй шинжтэй байдаг.

7. Монгол, англи хэлэнд эд юмны нэртэй холбогдон өнгө заасан нэр үүсэхэд гарч буй ялгаа тухайн холбогдож байгаа эд юм нь монгол, англи хэлтэн ард түмний хэл, соёлын ялгаагаар тайлбарлах боломжтой. Аль нэг хэлэнд энэ загвараар үүссэн нийлэмжинд холбогдож буй нэр нь тухайн ард түмний хувьд ойр байдаг, илүү таньсан юмтай холбоотой байна.

ABSTRACT

The pattern to make color name compound “noun + color name” is the most creative way in both languages, according to research evidence. Inside classification of this pattern is 9 in both languages; however, number of unit in each type and name is far different. The differences show mentality and cognitive ways of the nations and the features of their way of living.

НОМ ЗҮЙ

1. Berlin B, Kay P.(1966) Basic color terms: Their Universality and Evolution. Berkeley, CA, University of California Press
2. Дулам, С. (2007) “Монгол бэлгэдэл зүй II Өнгийн бэлгэдэл зүй, Зүг чигийн бэлгэдэл зүй”. УБ, 41
3. Ладос, Р.(2009) Лингвистика поверх границ культур. Новое зарубежной лингвистике, Вып. 25, М, 56
4. Нандин-Эрдэнэ, О. (2015) “Өнгө заасан нэрийг сэтгэц хэл шинжлэлийн үүднээс судлах нь” (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. УБ. 62-78
5. Фрумкина, Р.М. (1984) Цвет, смысл, сходство. М, 47-48
6. Цэвэл, Я. (1966) Монгол хэлний товч тайлбар толь. УБ
7. <http://www.thefreedictionary.com/>
8. <http://graphwords.com/>
9. <http://www.oxfordlearnersdictionaries.com/>
10. <http://www.macmillandictionary.com/us/thesaurus>

⁷ Фрумкина Р.М (1984) Цвет, смысл, сходство, М, 47-48